



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/НО

Арвайхээр сум

Аймгийн хууль, эрх зүйн сургалт,
сурталчилгааны ажлын 2024 оны нэгдсэн
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Засгийн газрын 1993 оны “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” 57 дугаар тогтоолын 3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 3.3.1.1, 3.3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2024 оны нэгдсэн төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2024 оны нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан сум, төсвийн байгууллага болон орон нутгийн өмчит компаниуд эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөө гарган сургалт, сурталчилгааны ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг байгууллагын удирдлагууд, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

4.Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (А.Отгонцэцэг)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.СУМЬЯАСҮРЭН

6224 17-0357

Аймгийн Засаг даргын 2024 оны 26 дугаар сарын 07-ны өдрийн 740 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.02.19

Арвайхээр сум

д/д	Эрх зүйн сургалт, сурталчилгааны агуулга, сэдэв	Зохион байгуулах хугацаа	Хамрах хүрээ	Хүрэх үр дүн	Сургалт, сурталчилгааны хэлбэр (Цахим, танхим)	Зохион байгуулах байгууллага	Хамтран зохион байгуулах байгууллага
Нэг. Шинээр дагаж мөрдсөн хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа							
1.1	Нийгмийн даатгалын ерөнхий хууль	1-2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид, иргэд	Иргэд, төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.2	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль	1-2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид, иргэд	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.3	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай	1-2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид, иргэд	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар

1.4	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай	1-2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид, иргэд	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.5	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай	1-2 дугаар улиралд	Төрийн албан хаагчид, иргэд	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
1.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	Жилдээ	Төрийн албан хаагчид	Төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Худалдан авах ажиллагааны газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
Хоёр. Төрийн албан хаагч, иргэд олон нийтэд чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа							
2.1	Төрийн албаны хаагчийн ёс зүйн хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Төрийн албан хаагч	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Цахим, танхим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, Сумдын Засаг даргын Тамгын газар
2.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	2 дугаар улирал	Төрийн албан хаагч, Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Цахим, танхим	Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.3	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ Жилийн турш	Төрийн албан хаагч	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Цахим, танхим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.4	Кибер аюулгүй байдлын тухай хууль	2 дугаар улирал	Төрийн албан хаагч, Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Цахим, танхим	Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим	Сумдын Засаг даргын Тамгын газар

						үйлчилгээний хэлтэс	
2.5	Зөвшөөрлийн тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Иргэд	Иргэд, төрийн албан хаагчдад хууль хэрэгжүүлэх арга зүйн чиглэл, зөвлөмж олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.6	Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн сургалт, сурталчилгаа	1-2 дугаар улиралд	Төрийн албан хаагч, Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, сангийн хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.7	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Төрийн албан хаагч, Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.8	Хууль зүйн туслалцааны тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Хууль зүйн туслалцааны төв	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.9	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа	2-3 дугаар улиралд	Төрийн албан хаагч, Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.10	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа	2-3 дугаар улиралд	Төрийн албан хаагч, Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
2.11	Хүний эрхийн хууль тогтоомжийн талаарх сургалт, сурталчилгаа	Жилдээ	Төрийн албан хаагч, Иргэд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс	Сумдын Засаг даргын Тамгын газар
Гурав. Хүүхэд, залуучуудад чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа							
3.1	Цахим орчин дахь хүүхэд хамгаалалын талаарх сургалт, сурталчилгаа	2 дугаар улирал	Хүүхэд, залуучуудад	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Цахим, танхим	Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар

3.2	Цахим орчин дахь гадуурхалтаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа	2 дугаар улирал	Хүүхэд, залуучуудад	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Цахим, танхим	Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
3.3	Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдад цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулах	2 дугаар улиралд	Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчид	Ахлах ангийн сурагчдын дунд, цэрэг эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлнэ.	Танхим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб	Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
3.4	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн талаарх сурталчилгаа	Жилдээ	Хүүхэд, залуучууд	Хүүхэд, залуучуудын эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	Цахим, танхим	Аймгийн Цагдаагийн газар	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар
3.5	Байгаль орчны тухай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн сургалт, сурталчилгаа	2-3 дугаар улиралд	Хүүхэд, залуучууд	Хүүхэд, залуучуудад эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар
3.6	Хүүхэд хамгааллын тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Хүүхэд, залуучууд	Хүүхэд, залуучуудад эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	Сумдын Засаг даргын Тамгын газар
3.7	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн сургалт, сурталчилгаа	Жилдээ	Залуучууд	Хүүхэд, залуучуудад эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс	Сумдын Засаг даргын Тамгын газар
3.8	Хүний эрхийн хууль тогтоомжийн талаарх сургалт, сурталчилгаа	Жилдээ	Хүүхэд, залуучууд	Эрх зүйн мэдлэг олгосон байна.	Танхим, Цахим	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүний эрхийн үндэсний комисс	Сумдын Засаг даргын Тамгын газар
Дөрөв.Хууль сурталчлах “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээ зохион байгуулах нэгдсэн хуваарь							

Д/д	Өдөрлөг зохион байгуулах байгууллагын нэр	Зохион байгуулах хугацаа	Хамрах хүрээ	Зохион байгуулагдах газар (байршил)	Хүрэх үр дүн	Хамтран зохион байгуулах байгууллага
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар	2024 оны 03 дугаар сард	Зөвлөгөө, мэдээлэл авахыг хүссэн иргэн	Аймгийн үйлчилгээ мэдээллийн болон байршилд	Төрийн төв бусад	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Аймгийн Төрийн үйлчилгээ мэдээллийн төв, Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс
2.	Биеийн тамир, спортын газар, Соёл, урлагийн газар					
3.	Боловсрол, шинжлэх ухааны газар; Стандарт, хэмжил зүйн хэлтэс	2024 оны 04 дүгээр сард				
4.	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс					
5.	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	2024 оны 05 дугаар сард				
6.	Мал эмнэлгийн газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв					
7.	Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	2024 оны 08 дугаар сард				
8.	Онцгой байдлын газар, Татварын хэлтэс					
9.	Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар	2024 оны 09 дүгээр сард				
10.	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба					
11.	Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Бүсийн шүүх шинжилгээний төв	2024 оны 10 дугаар сард				
12.	Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын алба), Эрүүл мэндийн даатгалын хэлтэс					

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

Аймгийн Засаг даргын 2024 оны 23 дугаар
сарын 04-ны өдрийн 1/40 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



**АЙМГИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН
2024 ОНЫ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨВ**

№	Задлын нэр	Төсөв
1.	Шинээр батлагдсан хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах	4,0 сая
2.	Төрийн албан хаагчдад чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах	4,0 сая
3.	Иргэд, олон нийтэд чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах	4,0 сая
4.	Хүүхдүүдэд, залуучуудад чиглэсэн эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах	4,0 сая
5.	Хууль сурталчлах “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээ зохион байгуулах	4,0 сая
Нийт зардал		20,0 сая